



**“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР”**  
**ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР**

Найрамдал талбай, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61027  
Утас: 976 (757) 7 35 01, Факс: (976) 7035 3002,  
Цахим шуудан: info@erdenetmc.mn,  
Цахим хаяг: www.erdenetmc.mn

2024.12.16 № ТНБ-134-12/7949  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас зарласан ЭҮТӨҮГ/20240103771 дугаартай "Үйлдвэрийн дүүрэгт ажилладаг ажилтнуудад халуун хоолоор үйлчилгээ үзүүлэх ажил-I" гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт оролцохыг сонирхогчоос Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-ээр дамжуулан гаргасан тодруулгын хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт .....<sup>1</sup> хуудастай.

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР



Т.БАТМӨНХ

ЭРДЭНЭС МОНГОЛ НЭГДЛИЙН ГИШҮҮН

612407039122

**Тодруулга №1-д:**

**Хариулт:** ТШЗ 19.1.1-ийн *Хүснэгт №1*-д заасан ажилтнуудын сургууль төгссөн дипломын хуулбарыг ирүүлэх шаардлагагүй. Төрийн мэдээлэл солилцооны ХУР системээр дамжуулан Боловсрол, шинжлэх ухааны яамны мэдээллийн сангаас шалгана. **ТШЗ-ийн 19.1.1.4 дэх заалтыг баримталж үнэлгээ хийх тул төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-Mongolia/-д санал болгосон ажилтнуудын дээд боловсролын дипломын мэдээлэл байршсан эсэхийг лавлах шаардлагатай. Дээрх мэдээлэл зөрүүтэй бүртгэгдсэн бол тендерийн нээлтээс өмнө БШУЯ-ны Мэдээллийн технологи статистикийн хэлтэст хандаж дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд бүртгүүлнэ үү. Дээрх бүртгэл хийгдээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болохыг анхаарна уу.**

**Тодруулга №2-т:**

**Хариулт:** Техникийн тодорхойлолтын 5.1 заалтын хариу: Хоол үйлдвэрлэл үйлчилгээ үзүүлэх байршил бүрд 1 ширхэг карт уншигч, компьютер, шим тэжээлийн мэдээлэл олгох дэлгэц, мөн техникийн тодорхойлолтын Хүснэгт 01-д заасан мармед үйлчилгээнд халуунаа барих зөөврийн боксийг авах, ажлын байруудтай танилцан бүх хэсгүүдийг камержуулна.

**Тодруулга №3-т:**

**Хариулт:** ТШЗ 19.1.3. Үйлчилгээ үзүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: “Шаардана”.

ТШЗ 19.1.3-ийн:

*“а. Тендерт оролцогч өөрийн эзэмшлийн болон түрээсийн гэрээний дагуу ашиглах машин механизм, тоног төхөөрөмжийг цахим систем дэх V бүлэгт заасан маягтаар зааварчилгааны дагуу санал болгоно. Цахим системээр санал болгоогүй тохиолдолд хянан үзэхгүй. Цахим системийн хэрэглэгчийн хөтөч цэсний нийлүүлэгчийн гарын авлага хэсгээс зааварчилгаатай танилцана уу.*

*ф. Тухайн ажилд санал болгож буй тээврийн хэрэгсэл, машин механизмын гэрчилгээ, лавлагааг ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан шаардлагатай мэдээллийг шалгана.” гэж заасан.*

**Иймд тендерт санал болгох техник, тээврийн хэрэгсэлд хамаарах шаардлагуудыг ТШЗ 19.1.3-т заасны дагуу бэлтгэж ирүүлнэ.**

**Техникийн тодорхойлолтын 7.4-т заасан Автотээврийн үндэсний төвийн олгодог тээврийн хэрэгслийн лавлагааг тендерийн үнэлгээнд харгалзан үзэхгүйг анхаарна уу.**

Техникийн тодорхойлолт болон тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлага зөрүүтэй тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ-ны зүйлийг баримтлан тендер бэлтгэж ирүүлнэ.

**Тодруулга №4-т:**

**Хариулт:** ТШЗ 24.1-д эрх бүхий банкны эсхүл даатгагчийн цахим тендерийн баталгааг цахимаар гаргаж мөн цахимаар ирүүлнэ. Энэхүү баталгааны хүчинтэй байх хугацаа тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байна. Тендер шалгаруулалтын баримт бичгийн 40 дүгээр хуудас дахь тендер шалгаруулалтын зарлалын 7 дугаар зүйлтэй танилцана уу.